

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Ачаа тээврийн даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Ачааны даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинэчлэн батлах тухай		2021-02-05		ЗТ-21/02-010	
6	Цахимаар борлуулах эсэх	Тийм					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Даатгуулагчийн өмчлөл эзэмшлийн ачаа, бараа					
	Даатгалын үндсэн эрсдэл	Байгаль, гал, зам тээврийн осол, хулгай дээрэм, гуравдагч					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.1%-9%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Дараах тохиолдолд даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзана. Үүнд:

1.1. Даатгуулагчийн доорх үйлдэлтэй холбоотой нөхцөлүүд:

- 1.1.1. Хорлон сүйтгэх үйлдэл;
- 1.1.2. Даатгалын зүйлийг зориулалтын бус, тохиромжгүй тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн, мөн зориулалтын бус чингэлэг, хайрцаг сав, агуулахад агуулсан;
- 1.1.3. Цаг хугацаа, температур, улирлын шинжтэй бүтээгдэхүүний тус онцлогийг харгалзалгүй тээвэрлэсэн;
- 1.1.4. Тээвэрлэлтийн явцад орсон аливаа өөрийн мэдэж байсан өөрчлөлтийг цаг тухайд нь даатгагчид мэдэгдээгүй бол;
- 1.1.5. Даатгалын зүйлийн өмчлөлд өөрчлөлт орсон талаар даатгагчид ажлын 5 хоногт багтаан мэдэгдээгүй бол;
- 1.1.6. Даатгуулагч болон түүний ажилтнууд хэвийн тээвэрлэлтийн үед даатгалын зүйлийг гэмтэж, хохирол учирхааргүй баглаж, бэхлээгүй бол;
- 1.1.7. Даатгуулагч даатгалын гэрээгээр болон холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд;
- 1.1.8. Хэрэв Даатгуулагч Монгол Улсын "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль"-д заасны дагуу Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглахтай холбоотой үйл ажиллагаа явуулсан тохиолдолд;

1.2. Даатгалын зүйлийн онцлог болон сав баглаа боодолтой холбоотой нөхцөлүүд:

- 1.2.1. Даатгалын зүйлийн хэвийн хорогдол, элэгдэл, ууршилт, алдагдал, жин хэмжээний багасалт;
- 1.2.2. Гадны нөлөөлөлгүйгээр даатгалын зүйл өөрийгөө устгах, шинж чанараа алдах;
- 1.2.3. Даатгалын зүйлийн хадгалалтын горим алдагдах, хугацаа хэтрэх, үйлдвэрлэлийн гэмтэл, гологдол;
- 1.2.4. Сав баглаа боодол, хамгаалалтын болон зөөх зориулалттай хийгдсэн сав, ачааны бэхэлгээ зэрэг нь шаардлага хангаагүйгээс;
- 1.2.5. Хамгаалалтын болон зөөх зориулалтаар хийгдсэн гадны нөлөөнөөс хамгаалсан сав баглаа боодол гэмтэхэд сав баглаа боодолд учирсан хохирол;
- 1.2.6. Даатгалын бус тохиолдлоор даатгалын зүйлийн хамгаалалтын болон зөөх зориулалтаар хийгдсэн гадны нөлөөнөөс хамгаалсан сав баглаа боодол гэмтсэнээс даатгалын зүйлд хохирол учрахад;
- 1.2.7. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх тухай хуульд заасны дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэсэн тохиолдолд;

1.3. Тээвэрлэгч болон тээвэрлэлттэй холбоотой нөхцөлүүд:

- 1.3.1. Тээвэрлэлтийн хугацаа хоцрох, тээвэрлэлт саатах, түүнээс үүдэлтэй хохирол;
- 1.3.2. Тээвэрлэлтийн явцыг саатуулж болох тээвэрлэгчийн төлбөрийн чадвар муудалт, санхүүгийн хүндрэл;
- 1.3.3. Тээвэрлэгч нь холбогдох дүрэм журам, заавар стандартыг зөрчсөн болон санаатайгаар даатгалын зүйлд хохирол учруулсан нь тогтоогдсон бол;

1.4. Онцгой нөхцөлүүд:

- 1.4.1. Даатгалтай ачаанд стандартын дагуу хамгаалалт, сав баглаа боодол хийгээгүйгээс үүдсэн зэврэлт, өнгө гандах, исэлдэж муудах;

- 1.4.2. Механик эвдрэл*-ээс шалтгаалсан хохирол, мөн даатгагдаагүй эрсдэлээс үүдсэн хохирол;
- 1.4.3. Ачаа барааг бүрэн хүлээж авснаас хойш учирсан хохирол;
- 1.5. **Газар зүйн нөхцөлүүд:** *(Доорх бүс нутаг, улс орнууд руу тээвэрлэсэн болон тэндээс тээвэрлүүлсэн аливаа ачаа бараа, эсхүл эдгээр улс орнуудыг дамжин өнгөрөхөд учирсан хохирол)*
 - 1.5.1. Зүүн Африк, баруун Африк, төв Африк, өмнөд Африк;
 - 1.5.2. Олон улсын Ачаа Тээврийн Нэгдсэн Хороо (JCC-Joint Cargo Committee)-с зарладаг жагсаалт*-д онцгой, өндөр зэрэглэлийн эрсдэлтэй буюу эрсдэлийн үнэлгээ нь 3,2-оос дээш гэж тусгагдсан улс орнууд;
- 1.6. **Бусад нөхөн төлбөр олгохгүй нөхцөлүүд:**
 - 1.6.1. Гуравдагч этгээдийн улс төр, үзэл санаа, шашны, танхай сэдэлтэй үйлдэл;
 - 1.6.2. Хулгай;
 - 1.6.3. Хүрээлэн буй орчинд, тээвэрлүүлж буй тээврийн хэрэгсэлд болон гуравдагч этгээдэд учруулсан эрсдэл;
 - 1.6.4. Даатгалын тохиолдлоос үүдсэн эдийн засгийн хохирол;
 - 1.6.5. Даатгалын зүйлийг засварлах зардал нь зүйлийн өөрийн үнээс давсан хэсгийг;
 - 1.6.6. Гаалийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэл, зардал;
 - 1.6.7. Хууль тогтоомжид заасан бусад.